

**ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ АНХДАГЧ
ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2020 он

УДИРТГАЛ

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай анхдагч хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”¹ /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Уг аргачлалд заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог бөгөөд Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл дэх зохицуулалтууд нь төрийн байгууллага болон хуулийн этгээдэд зардал үүсгэх бөгөөд иргэнд гомдол гаргах зардал үүсч байна.

Иймд хуулийн төслийн зардлыг урьдчилан тооцохдоо түүнийг хэрэгжүүлэх төрийн байгууллага болон хуулийн этгээдэд үүсэх зардлыг тоймлон гаргах, хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа үүргийн хүрээнд зардал үүсгэх боломжтой зүйл, заалтуудыг авч үзэн зардал тус бүрээр тооцож, мөн эдгээр байгууллагад үүсэх зардал, ачааллыг бууруулах боломжтой эсэхийг судлан, боломжит хувилбарыг дэвшүүлэхийг зорьсон.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно. Үүнд:

- гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.
-

Нэг.Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн анхдагч хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал

Энэхүү хуулийн төслийн төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараахь үе шаттайгаар гаргалаа. Үүнд:

1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоох;
3. Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягтлах.

Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн түүвэрлэн, хийж гүйцэтгэх үйл явцын дагуу уялдаа холбоог харгалзан тодорхойлсон. Ийнхүү тодорхойлохдоо ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах нь зүйтэй.

¹ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын Хавсралт 1

Үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг тооцохдоо төрийн байгууллагад хийгддэг адил төстэй үйлчилгээг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн ажилбарт ажлын байрны зураг авалтын үр дүнд гаргасан хугацаан дээр үндэслэн тэдгээрийн гүйцэтгэх хугацааг тодорхойлон тооцлоо.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200² өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /хөдөлмөрийн хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу /200 x 8/ 1600 ажлын цаг буюу /1,600 x 60/ 96000 минут ажиллана.

1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох

Хүний эрхийн Үндэсний Комисс

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн Зургадугаар бүлэгт хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагаар Хүний эрхийн үндэсний комиссыг тогтоож, хувь хүний мэдээлэл хамгаалах нэмэлт чиг үүргийг хуулийн холбогдох зүйл, заалтуудад тогтоосон. Иймд Хүний эрхийн Үндэсний Комисст үүсэх хүний нөөцийн зардлыг доор дурдсанаар тооцно.

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт
9.2.Хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комисс мэдээлэл хариуцагчид зөвлөмж өгч болно.
22.6.Энэ хуулийн 22.4-т заасан бүртгэлийг жил бүр Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлэх ба түүний шаардсанаар тухай бүр хүргүүлнэ.
23.2.Энэ хуулийн 23.1-д заасан үнэлгээг Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлж, зөвлөмж гаргуулсны үндсэн дээр цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглана.
23.3.Энэ хуулийн 23.1-д заасан үнэлгээ хийх аргачлал, журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.
24.1.1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах, энэ талаар холбогдох байгууллагад зөвлөмж, шаардлага хүргүүлэх, холбогдох журамд санал өгөх;
24.1.2.мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмж, шаардлага хүргүүлэх;
24.1.3.мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах үйл ажиллагааны явцад энэ хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөнд халдсан, эсхүл халдаж болзошгүй нөхцөл бүрдүүлсэн гэж үзвэл энэ талаар ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаж, шийдвэрлэх, эсхүл өөрийн санаачилгаар шалгаж, шийдвэрлэх, уг асуудлаар холбогдох байгууллагуудад зөвлөмж, шаардлага хүргүүлэх;

²Хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

24.1.4.хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагуудад хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх;
24.1.5.мэдээлэл хариуцагчийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний талаар ирүүлсэн бүртгэлийг хүлээн авч хянан, цаашид анхаарах зүйлийн талаар зөвлөмж өгөх;
24.1.6.мэдээлэл хариуцагчийн энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж өгөх;
24.1.7.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд мэдээлэл хамгаалах үйл ажиллагаа, гарсан зөрчил, мэдээллийн эзний эрхийн хэрэгжилтийн талаар тусгах.

2.Хүний нөөцийн хэрэгцээг тогтоох

Хуулийн төсөлд тусгагдсан Хүний эрхийн Үндэсний Комиссын нэмэлт чиг үүргийн онцлогоос хамаарч давтамжийг өөр өөрөөр тогтоолоо.

Мэдээлэх үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
10.4.Энэ хуулийн 10.3-т заасан шийдвэрийг хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага болон харилцаа холбоо, мэдээлэл технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хамтран баталсан биометрик мэдээллийг цуглуулах, ашиглах журамд нийцүүлж гаргана.	Журам боловсруулж, батлах	танилцах, мэдээллээ үнэлэх	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
		боловсруулах	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240

21.3.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 21.1-д заасны дагуу үнэлгээ хийх аргачлал, журмыг хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага болон харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран тогтооно.	Журам боловсруулж, батлах	танилцах, мэдээллээ үнэлэх	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
		боловсруулах	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
22.3.1.мэдээллийн эзнээс ирүүлсэн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх;	Гомдол шийдвэрлэх	Хариуг боловсруулж хүргүүлэх	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	600	148000
22.3.2.мэдээлэл хариуцагч болон боловсруулагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлага хүргүүлэх;	Шаардлага хүргүүлэх	Шаардлага боловсруулж, хүргүүлэх	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	600	39840
22.3.3.мэдээлэл хамгаалах талаар олон улсын байгууллагатай хамтран ажиллах;	Хамтран ажиллах талаар хүсэлт хүргүүлэх	боловсруулах	2 өдөр /16цаг/ 960 мин	10	9600
		Хүсэлт хүргүүлэх	2 өдөр /16цаг/ 960 мин	10	9600
22.3.4.мэдээлэл боловсруулахтай холбоотой мэдээллийн эзний эрхийг олон нийтэд таниулах;	Нийтэд мэдээллэх	мэдээлэл боловсруулах	3 өдөр /24цаг/ 1440 мин	10	14400
		Нийтэд мэдээлэх	2 өдөр /16цаг/ 960 мин	10	9600

22.3.5.мэдээлэл эзний эрхийг хамгаалах талаар мэдээлэл хариуцагч болон боловсруулагчид хууль эрх зүй, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;	Зөвлөгөө өгөх	Биечлэн	10 мин	100	1000
		Утсаар	2 мин	100	2000
		Цахимаар	5 мин	100	5000
22.3.6.мэдээлэл цуглуулах зөвшөөрлийн маягтыг батлах;	Маягт боловсруулж, батлуулах	танилцах, мэдээллээ үнэлэх	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
		боловсруулах	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
22.3.7.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд мэдээлэл хамгаалах үйл ажиллагаа, гарсан зөрчил, мэдээллийн эзний эрхийн талаар тусгаж, жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд тайлагнах;	Мэдээлэл бэлтгэх	мэдээлэл цуглуулах	2 өдөр /16цаг/ 960 мин	4	3840
		танилцах, мэдээллээ үнэлэх	2 өдөр /16цаг/ 960 мин	4	3840
		Тайлан боловсруулах	1 өдөр /8 цаг/ 480 мин	4	1920
		оролцох	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	4	960
22.3.8.хувь хүний эмзэг мэдээлэл боловсруулах үйл ажиллагаанд баримтлах журмыг боловсруулж, батлах;	Журам боловсруулж, батлуулах	танилцах, мэдээллээ үнэлэх	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
		боловсруулах	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
22.3.9.үнэлгээ хийх аргачлал, журмыг батлах.	Журам боловсруулж, батлуулах	танилцах, мэдээллээ үнэлэх	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
		боловсруулах	2 өдөр /16цаг/ 960 мин	1	960

		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240
Нийт					480000

3.Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох

Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараахь байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс	480000 мин	96000	5

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр Хүний эрхийн үндэсний комиссод үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана.

Хүний эрхийн үндэсний комиссын цалингийн хэмжээ

Албан тушаалын зэрэглэл	Албан тушаалын нэр	Сарын цалин (төгрөгөөр)
АА-1	Ажлын албаны дарга	1,108,741
АА-4	Хэлтсийн дарга	1,027,338
АА-5	Ахлах референт	984,175
АА-6	Референт	944,097
АА-7	Ахлах шинжээч	871,230
АА-8	Шинжээч	838,108
АА-9	Ахлах мэргэжилтэн	804,986
Дундаж цалин		939,810

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ХЭҮК-ын ажлын хөлсийг тогтоохдоо “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хүний эрхийн үндэсний комиссын ажлын албаны цалингийн сүлжээ”-ээс дундаж цалингийн хэмжээг тооцож, холбогдох нэмэгдлүүдийг тооцохгүйгээр **ХЭҮК-ийн ажилтнуудын сарын дундаж цалинг 939 810 төгрөг** байхаар тооцов.

Хүний нөөцийн зардал

Нэгж	Цалингийн зардал /төг/	Орон тооны ачаалал	Сар	Хүний нөөцийн нийт зардал /төг/
ХЭҮК Ажлын алба	939,810	5	12	56,388,600
Нийт хүний нөөцийн зардал жилд				56,388,600

4.Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох

Нийт дүнг тооцохдоо төрийн байгууллагаас гарах нийт зардлыг тооцох бөгөөд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр нийт зардлыг тооцон гаргана.

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн хүрээнд гарах материаллаг зардлын тооцоо

№	Зардлын нэрс	Хуулийн хэрэгжилттэй холбоотой гарах нэмэлт зардал нэгжээр	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Бичиг хэргийн материал	1,016,445	1	1,016,445
2	Тээвэр шатахуун	1,454,294	1	1,454,294
3	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	180,734	1	180,734
4	Хангамжийн материал	543,331	1	543,331
5	Сургалтын зардал	11,504,030	1	11,504,030
6	Бусад зардал	48,766	1	48,766
Дүн		14,747,600		14,747,600

Үүнээс харахад төрийн байгууллагад үүсэх нийт зардал нь жилд:
56,388,600+ 14,747,600 = 71,136,200 төгрөг байна.

5.Хувилбарыг нягтлах

Хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах ажлыг энэхүү үе шатанд хийж гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, төсвийн зардлыг багасгах боломж бий эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг тогтооно.

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар
1.	Боловсруулан, батлах журмын тоог багасгах	Боломжгүй	Хуулиар үүрэгжүүлсэн.
2.	Судалгааны мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх	Боломжгүй	Судалгаа ач холбогдолгүй болно.
3.	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх	Боломжтой	Өмнө нь хийгдэж байсан ажлууд бөгөөд Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн дэлгэрэнгүй байдлаар хуульчлагдсан.
4.	Зарим баримт бичгийг боловсруулах хугацааг багасгах боломжтой эсэх	Боломжтой	
5.	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх	Боломжгүй	Мэдээллийн хүртээмж буурна.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан зарим үүргүүд нь одоо хийгдэж байгаа ажиллагааг нарийвчлан хуульчилж өгсөн тул нэмэлтээр үүсэх зардал буурах боломжтой. Түүнчлэн гомдол гаргах тохиолдлын тоог статистик тоо мэдээнээс өндрөөр тооцсон тул энэ тохиолдлын тоо буурч зардал буурах боломжтой байна.

Дүгнэлт

“Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай” хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад жилд нийт **44,069,672** төгрөгийн зардал гарахаар тооцов.

Дээрх зардал тооцогдсон хуулийн заалтын хүрээнд хийгддэг үйл ажиллагаанууд нь Хүний эрхийн үндэсний комисст үүсэх шинэ чиг үүргийг илүү нарийвчлан хуульчилсан юм. Иймд энэхүү зардлын тооцоогоор гарсан зардал нь одоо мөрдөж байгаа зардал дээр нэмэгдэх болно.

Хоёр.Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн анхдагч хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардал

“Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай” хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээд нь *Мэдээлэл хариуцагч* болон *Мэдээлэл боловсруулагч* байх бөгөөд эдгээрийн явуулж байгаа үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран мэдээллийн технологийн систем болон түүний нэвтрүүлэлт зэрэг нь харилцан адилгүй тул уг хууль батлагдан гарсны дараа хуулийг хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал нь ялгаатай байх болно.

Хуулийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцоолохдоо Хууль тогтоомжийн тухай хууль, холбогдох аргачлал, гарын авлагад заасны дагуу хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг нэг бүрийг тогтоосон. Гүйцэтгэх үүрэг гэдгийг тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг ойлгохоор тусгасан байна.

Хуулийн этгээдийн хувьд хуулийн төсөлд заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлыг дараах шат дарааллаар тооцсон. Үүнд:

1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. Зардлыг тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Нийт зардлын дүнг тооцож гаргах;
5. Хялбарчлах боломжийг шалгах;
6. Нэмэлт зардлыг тооцох.

1.Иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох

Хуулийн төсөл дэх холбогдох заалтууд / Үүрэг буюу Үйл ажиллагаа
9.3.Мэдээлэл хариуцагч нь хувь хүний эмзэг мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагаас гаргасан шаардлагыг хангаж, зөвшөөрөл авсан байна.

10.3.Хуулиар иргэн, хуулийн этгээдэд биометрик мэдээллийг цуглуулах, ашиглах талаар тусгайлан эрх олгоогүй тохиолдолд мэдээлэл хариуцагч тодорхой үйл ажиллагааны таньж, баталгаажуулах үйлдлийг хялбарчлах зорилгоор Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад урьдчилан мэдэгдэж шийдвэр гаргуулсны үндсэн дээр уг мэдээллийг цуглуулж, ашиглана.

20.2.Зөрчил нь мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол мэдээлэл хариуцагч нэн даруй мэдээллийн эзэн болон Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад мэдэгдэнэ.

20.3.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зориулалттай мэдээллийн системийн аюулгүй байдал алдагдсан, кибер халдлагад өртсөн бол Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад мэдэгдэнэ.

20.7.Энэ хуулийн 20.4-т заасан бүртгэлийг улирал бүр Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад хүргүүлэх ба түүний шаардсанаар тухай бүр хүргүүлнэ.

21.1.Мэдээлэл хариуцагч шинэ технологи ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад дараах тохиолдолд нөлөөллийн үнэлгээ хийж, Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад хүргүүлнэ.

23.7.Дүрс бичлэгт байгаа хувь хүнийг тодорхойлох зорилгоор дүрс бичлэгийг хүний оролцоогүй цахимаар боловсруулж, шийдвэр гаргах системийг нөлөөллийн үнэлгээ хийж, Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр ашиглана.

2.Зардлыг тооцох

Аргачлалын 2.4.-т заасан зардлыг тооцохын тулд ажилтны ажлын хөлс, мэдээлэл бэлтгэн гаргахтай холбогдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн хугацааг нэг бүрчлэн тогтооно гэсэн байна. Тиймээс хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийн хугацааг нарийвчлан тооцохдоо Хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загварыг ашигласан болно.

Зардал (ҮА тус бүрийн)=Хугацаа х Ажлын хөлс

“Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай” хуулийн төсөлд хамрагдаж буй хуулийн этгээдэд хувь хүний мэдээлэлтэй харьцдаг бүхий л салбарын байгууллага, хуулийн этгээдүүд хамаарах тул ажилтны ажлын хөлсийг Үндэсний статистикийн хорооноос гаргасан аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2019 онд улсын хэмжээнд 1 124 300 төгрөг байснаар тооцсон болно.

Ажлын хөлс=Үндсэн цалин / Ажиллах хугацаа (нэг сараар)

Иймд хуулийн этгээдийн ажилтны 1 сарын дундаж цалин **1 124 300** төгрөг, үүнийг 1 сард ажлын 22 өдөр байна гэж тооцвол нэг минутын ажлын хөлс нь **106.5** төгрөг байна.

Зардлын тооцоо

Үйл ажиллагаа (ҮА)/ Гүйцэтгэх үүрэг	Холбогдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа (мин)	Зардал (төг)
-------------------------------------	--	-------------------------	--------------

9.3.Мэдээлэл хариуцагч нь хувь хүний эмзэг мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагаас гаргасан шаардлагыг хангаж, зөвшөөрөл авсан байна.	Холбогдох маягт бөглөж, өргөдөл өгөх	15	1600
10.3.Хуулиар иргэн, хуулийн этгээдэд биометрик мэдээллийг цуглуулах, ашиглах талаар тусгайлан эрх олгоогүй тохиолдолд мэдээлэл хариуцагч тодорхой үйл ажиллагааны таньж, баталгаажуулах үйлдлийг хялбарчлах зорилгоор Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад урьдчилан мэдэгдэж шийдвэр гаргуулсны үндсэн дээр уг мэдээллийг цуглуулж, ашиглана.	Холбогдох маягт бөглөж, өргөдөл өгөх	15	1600
20.2.Зөрчил нь мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол мэдээлэл хариуцагч нэн даруй мэдээллийн эзэн болон Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад мэдэгдэнэ.	Холбогдох байгууллагад мэдэгдэх	5	533
20.3.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зориулалттай мэдээллийн системийн аюулгүй байдал алдагдсан, кибер халдлагад өртсөн бол Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад мэдэгдэнэ.	Холбогдох байгууллагад мэдэгдэх	5	533
20.7.Энэ хуулийн 20.4-т заасан бүртгэлийг улирал бүр Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад хүргүүлэх ба түүний шаардсанаар тухай бүр хүргүүлнэ.	Бүртгэлийг хүргүүлэх /цахимаар/	3	320
21.1.Мэдээлэл хариуцагч шинэ технологи ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад дараах тохиолдолд нөлөөллийн үнэлгээ хийж, Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад хүргүүлнэ.	Үнэлгээ хийж, хүргүүлэх	30	3200
23.7.Дүрс бичлэгт байгаа хувь хүнийг тодорхойлох зорилгоор дүрс бичлэгийг хүний оролцоогүй цахимаар боловсруулж, шийдвэр гаргах системийг нөлөөллийн үнэлгээ хийж, Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр ашиглана.	Үнэлгээ хийж, хүргүүлэх	30	3200

3.Тоон үзүүлэлтийг тооцох

Аргачлалын 2.5-д тоон үзүүлэлтийг тооцохдоо тухайн үүргийг холбогдох хуулийн этгээд хэдэн удаа хэрэгжүүлэхийг хуанлийн 1 жилээр тооцож гаргана гэж заасан.

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлд хамаарах дээрх үүргийг хүлээх хуулийн этгээд нь хувь хүний эмзэг мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашигладаг, мөн шинэ технологи ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашигладаг, хувь хүнийг тодорхойлох зорилгоор дүрс бичлэгийг хүний оролцоогүй цахимаар боловсруулж, шийдвэр гаргах систем ашигладаг хуулийн этгээдийг хамруулна. Иймд эдгээр хуулийн этгээдэд мэдээлэл холбоо, банк, санхүүгийн болон даатгал, боловсрол, хүний эрүүл мэнд болон нийгмийн үйл ажиллагааны салбарын байгууллагыг хамруулж Хүснэгт 3-т үзүүлсэн статистикаас барагцаалан сонгож тооцсон ба нийт нийт **12 055** хуулийн этгээд байна.

Аж ахуйн нэгж байгууллагын тоо, 2020 оны III улирлын байдлаар

Мэдээлэл, холбоо	2,119
Банк ³	13
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2,531
Боловсрол	4,620
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2,772

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлд тохиолдлын тоо гэдэгт тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг, харин давтамжийн тоо нь тухайн үүргийг гүйцэтгэх хуулийн этгээд 1 жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг харуулна.

Тоон үзүүлэлт = Тохиолдлын тоо х Давтамжийн тоо

Тоон үзүүлэлт

Үүрэг, үйл ажиллагаа (ҮА)	Тохиолдлын тоо	Давтамжийн тоо	Тоон үзүүлэлт
9.3.Мэдээлэл хариуцагч нь хувь хүний эмзэг мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагаас гаргасан шаардлагыг хангаж, зөвшөөрөл авсан байна.	12,055	1	12,055
10.3.Хуулиар иргэн, хуулийн этгээдэд биометрик мэдээллийг цуглуулах, ашиглах талаар тусгайлан эрх олгоогүй тохиолдолд мэдээлэл хариуцагч тодорхой үйл ажиллагааны таньж, баталгаажуулах үйлдлийг хялбарчлах зорилгоор Хувь хүний	12,055	1	12,055

³ <https://www.mongolbank.mn/aboutus.aspx?id=002>

мэдээлэл хамгаалах байгууллагад урьдчилан мэдэгдэж шийдвэр гаргуулсны үндсэн дээр уг мэдээллийг цуглуулж, ашиглана.			
20.2.Зөрчил нь мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол мэдээлэл хариуцагч нэн даруй мэдээллийн эзэн болон Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад мэдэгдэнэ.	42	1	42
20.3.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зориулалттай мэдээллийн системийн аюулгүй байдал алдагдсан, кибер халдлагад өртсөн бол Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад мэдэгдэнэ.	48	1	48
20.7.Энэ хуулийн 20.4-т заасан бүртгэлийг улирал бүр Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад хүргүүлэх ба түүний шаардсанаар тухай бүр хүргүүлнэ.	48	1	48
21.1.Мэдээлэл хариуцагч шинэ технологи ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад дараах тохиолдолд нөлөөллийн үнэлгээ хийж, Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад хүргүүлнэ.	12,055	1	12,055
23.7.Дүрс бичлэгт байгаа хувь хүнийг тодорхойлох зорилгоор дүрс бичлэгийг хүний оролцоогүй цахимаар боловсруулж, шийдвэр гаргах системийг нөлөөллийн үнэлгээ хийж, Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр ашиглана.	12,055	1	12,055

Мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах зөрчлийг Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад мэдэгдэх үйл ажиллагааны давтамжийн тоог тооцохдоо Цагдаагийн байгууллагад мэдүүлсэн Хувь хүний хувийн мэдээлэл болох үндэс угсаа, арьсны өнгө, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлагаар гүтгэн доромжилсон талаар гомдол, мэдээлэл болон мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээнд ил болгосон талаарх гомдолын статистикаар буюу сүүлийн 3 жилийн байдлаар нийт 125 гомдол бүртгэгдсэн ба дунджаар 41.7 (42) гэж баримжаалав. Харин мэдээллийн системийн аюулгүй байдал алдагдсан, кибер халдлагад өртсөн талаар мэдээг Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад хүргүүлэх үйл ажиллагааны давтамжийн тоог тооцоолохдоо Монгол Улсад

бүртгэгдсэн Цахим мэдээллийн аюулгүй байдлын гэмт хэргийн сүүлийн 3 жилийн статистикийн⁴ дунджаар буюу 47.7 (48) гэж баримжаалсан болно.

4.Нийт зардлыг тооцох

Нийт зардлыг тооцохдоо тухайн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлж гаргана.

Нийт зардал =Зардал х Тоон үзүүлэлт

Нийт зардлын тооцоо

Үүрэг, үйл ажиллагаа (ҮА)	Зардал	Тоон үзүүлэлт	Нийт зардал (төг)
9.3.Мэдээлэл хариуцагч нь хувь хүний эмзэг мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагаас гаргасан шаардлагыг хангаж, зөвшөөрөл авсан байна.	1600	12,055	19,288,000
10.3.Хуулиар иргэн, хуулийн этгээдэд биометрик мэдээллийг цуглуулах, ашиглах талаар тусгайлан эрх олгоогүй тохиолдолд мэдээлэл хариуцагч тодорхой үйл ажиллагааны таньж, баталгаажуулах үйлдлийг хялбарчлах зорилгоор Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад урьдчилан мэдэгдэж шийдвэр гаргуулсны үндсэн дээр уг мэдээллийг цуглуулж, ашиглана.	1600	12,055	19,288,000
20.2.Зөрчил нь мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол мэдээлэл хариуцагч нэн даруй мэдээллийн эзэн болон Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад мэдэгдэнэ.	533	42	22,386
20.3.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зориулалттай мэдээллийн системийн аюулгүй байдал алдагдсан, кибер халдлагад өртсөн бол Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад мэдэгдэнэ.	533	48	25,584
20.7.Энэ хуулийн 20.4-т заасан бүртгэлийг улирал бүр Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад хүргүүлэх ба түүний шаардсанаар тухай бүр хүргүүлнэ.	320	48	15,360
21.1.Мэдээлэл хариуцагч шинэ технологи ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад дараах тохиолдолд нөлөөллийн үнэлгээ хийж, Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагад хүргүүлнэ.	3200	12,055	38,576,000

⁴ Цахим мэдээллийн аюулгүй байдлын гэмт хэрэг 2017 онд 44, 2018 онд 42, 2019 онд 57 тус тус бүртгэгдсэн байна. (ҮСХ, Гэмт хэргийн статистик, 2019)

23.7.Дүрс бичлэгт байгаа хувь хүнийг тодорхойлох зорилгоор дүрс бичлэгийг хүний оролцоогүй цахимаар боловсруулж, шийдвэр гаргах системийг нөлөөллийн үнэлгээ хийж, Хувь хүний мэдээлэл хамгаалах байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр ашиглана.	3200	12,055	38,576,000
НИЙТ			115,791,330

5.Хялбарчлах боломжийг шалгах

Хялбарчлах боломжийг шалгахдаа өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана.

Хялбарчлах боломжтой эсэх

№	Асуулт	Боломжтой эсэх	Тайлбар
1	Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх	Боломжгүй	Хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийг статистикаас барагцаалж буюу нийт нийт 12,055 хуулийн этгээд байна гэж үзсэн ба энэ тоо нь цаашид нэмэгдэх тул багасгах боломжгүй.
2	Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх	Боломжгүй	Тухайн хувийн хэвшлийн байгууллагуудын нийт хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн тооноос шууд хамааралтай тул тэдгээр тоог багасгах боломжгүй гэж үзэж байна.
3	Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх	Боломжтой	Тухайн мэдээллийн эзнээс ямар зөвшөөрөл авах, хувийн мэдээлэл боловсруулах аргаас хамааран мэдээллийн агуулга янз бүр байх тул багасгах боломжтой гэж үзэж байна.
4	Шинээр үүсэх үүргийг өмнө нь байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх	Боломжгүй	Иргэн буюу хувь хүнээс хувийн мэдээллийг нь цуглуулах, ямар зорилгоор цуглуулж, боловсруулах талаар зохицуулалт байхгүй тул энэ нь шинэ заалт учир нэгтгэх боломжгүй.
5	Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх	Боломжтой	Бүрэн боломжтой. Иргэн буюу мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах, түүнд иргэн мэдээлэх үйл ажиллагааг цахимаар буюу имэйлээр эсхүл тухайн хувийн хэвшлээс нэвтрүүлсэн цахим хуудас, аппликэйшн зэргийг ашиглан мэдээлэл хүргүүлэх боломжтой.
6	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог	Боломжгүй	Хувийн хэвшлийн зүгээс хувийн мэдээлэл боловсруулсан тухай мэдээллийг Хүний эрхийн үндэсний комисс болон мэдээллийн эзэн гэсэн 2

	багасгах боломжтой эсэх		субъектэд хүргүүлж байгаа тул энэ тоог багасгах боломжгүй.
7	Нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх	Боломжгүй	Уг хуулийн төслийн хүрээнд хувийн хэвшлийн байгууллагууд иргэдээс хувийн мэдээлэл боловсруулах зөвшөөрөл авах тул хувийн хэвшлүүдийг нэгтгэсэн нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжгүй гэж үзэж байна.

6.Нэмэлт зардлыг тооцох

Нэмэлт зардлыг шаардлагатай тохиолдолд “бусад зардлыг х тоон үзүүлэлт” гэсэн томъёоллоор үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч болох нэмэлт зардлыг тооцох бөгөөд тухайн үүргийг хэрэгжүүлэх явцад өөр ямар нэмэлт зардал гарч болохыг сайтар бодож, хамтад нь тооцох шаардлагатай.

Европын холбоонд хэрэгжиж эхэлсэн “Мэдээлэл хамгаалах ерөнхий зохицуулалт буюу GDPR” -ийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг хуулийн этгээдүүдэд үүсэх хувь хүний мэдээлэл хамгаалах талаар гарсан зөрчилтэй холбоотой торгуулийн хэм, хэмжээгээр тогтоосон байна.

Иймд Монгол улсын хэмжээнд Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдүүдэд үүсэх нэмэлт зардал буюу хувь хүний мэдээллийг хамгаалах талаар гарсан зөрчилтэй холбоотой торгуулийн хэм, хэмжээг бусад улс орнуудтай харьцуулан судлав.

4	Эстон		Эстоны Мэдээлэл хамгаалах хяналтын алба торгуулийн хэм хэмжээг тогтоохоор заасан	18977.39	4071.09	4.7	
5	БНСУ		113500000	26152.03	4071.09	6.4	17,668,560
6	Канад	Хуулийн этгээд	198000000	51315.89	4071.09	12.6	15,708,113
		Хувь хүн	19800000	51315.89	4071.09	12.6	1,570,811
7	Сингапур		Торгуулийн хэмжээг комисс хариуцна	55235.51	4071.09	13.6	
8	Швейцар		25700000	76667.44	4071.09	18.8	1,364,686
9	Япон	Хуулийн этгээд	682500000	48556.93	4071.09	11.9	57,221,882
		Хувь хүн	22750000	48556.93	4071.09	11.9	1,907,396

Дээрх хүснэгтээс дүгнэвэл бусад улс орнуудад Мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчигчдийг торгох торгуулийн хэмжээ болон нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нь ойролцоогоор 5~19 дахин их бөгөөд хуулийн этгээд нь хувь хүнээс даруй 10 дахин их үнийн дүнгээр торгуулж байгааг харж болохоор байна. Иймд Монгол улсын хувьд хуулийн этгээдийг торгох торгуулийн хэмжээг бусад улсуудын хувь хүнийг торгох торгуулийн хэмжээтэй дүйцүүлэн тооцож 1,500,000 төгрөг байхаар тооцоолов.

Нэмэлт зардал

Үйл ажиллагаа	Торгууль	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Зөрчлийн тухай хуулийн дагуу авах арга хэмжээ	1,500,000	42 (ЦЕГ-д жилд дунджаар гаргасан иргэдийн гомдлын тоо)	63,000,000
НИЙТ			63,000,000

Дүгнэлт

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдэд жилд нийт

115,791,330 + 63,000,000 = 178,791,330 төгрөгийн зардал гарахаар тооцсон бөгөөд 1 хуулийн этгээдэд 15,000 төгрөгийг ачаалал үүсгэхээр байна.

Дээрх зардал тооцогдсон хуулийн заалтын хүрээнд хийгддэг үйл ажиллагаанууд нь хуулийн этгээдэд үүссэн шинэ чиг үүргүүдийг илүү нарийвчлан хуульчилсан юм. Иймд энэхүү зардлын тооцоогоор гарсан зардал нь одоо мөрдөж байгаа зардал дээр нэмэгдэх болно.

Гурав.Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн анхдагч хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардал

Иргэний зардал, ачааллыг тооцох ажлыг дараах үе шаттайгаар тооцсон. Үүнд:

1. иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
3. тоон үзүүлэлтийг тооцох;
4. нийт дүнг тооцож гаргах;
5. хялбарчлах боломжийг шалгах.

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлд иргэнийг Мэдээллийн эзэн гэж тодорхойлсон ба гүйцэтгэх үүргийг нэг бүрчлэн тогтооход Аргачлалын 2.3-г баримтлана. Иймд хуулийн төсөлд иргэний гүйцэтгэх үүрэг үүсэхгүй тул холбогдох зардал гарахгүй гэж үзсэн болно.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалд заасны дагуу хэмжигдэхүйц зардлыг тооцсон болно. Үүнд:

1.Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллага болох Хүний эрхийн үндэсний комиссын хариуцах нэмэлт чиг үүргийг тусгасан. Иймд эдгээр заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг аргачлалын 4.3.3-т заасны дагуу хэмжих боломжтой ажлыг тооцсон бөгөөд хуулийн төслийн заалтуудад заасан ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг тооцоход нийт төрийн байгууллагад жилд нийт **71,136,200 төгрөгийн** зардал гарахаар байна.

2.Хуулийн этгээдэд хамаарах Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлд тусгагдсан заалтууд нь шинэ тутам тул хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон **178,791,330 төгрөгийн** зардал гарах тооцоо гарсан.

3.Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн заалттай холбоотой иргэнээс гарах зардал үүсэхгүй болно.

Тус хуулийн төсөл батлагдсанаар гарах зардал нь үр өгөөжтэй харьцуулахад үлэмж бага буюу үр ашиг зардлын харьцаа өндөр байна.

Ашигласан материал:

- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын 2016 оны “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 45 дугаар тогтоолоор Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны тайлан, 2016-2018;
- Цахим мэдээллийн аюулгүй байдлын гэмт хэрэг 2017 онд 44, 2018 онд 42, 2019 онд 57 тус тус бүртгэгдсэн байна. (ҮСХ, Гэмт хэргийн статистик, 2019)
- [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](http://1212.mn)

---oOo---